



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/604

Улаанбаатар хот

Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1.2 дахь хэсэг, 7.6 дахь хэсэг, “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм”-ийн 3.3.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дэргэдэх “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөнийг холбогдох хууль, журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж, шийдвэрийн хэрэгжилтийг ханган, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд холбогдох хөрөнгийн хөдөлгөөн хийгдсэн эсэхэд хяналт тавьж, ажиллахыг комиссын дарга /Д.Төмөрбаатар/-д, татан төвлөрүүлж буй хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулах, хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын тайланг улирал бүр танилцуулж ажиллахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төвийн дарга /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/267 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 12 дугаар сарын
18... өдрийн 0/604 дугаар тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн
хариуцсан комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга:

Д.Төмөрбаатар

Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч

Гишүүд:

А.Мөнгөн

Захиргаа санхүүгийн хэлтсийн даргын
үүрэг гүйцэтгэгч

М.Мандах

Өмчийн мэдээлэл, хяналт ашиглалтын
хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

Д.Итгэл

Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн
даргын үүрэг гүйцэтгэгч

С.Ариунжаргал

Өмчийн төлөөлөл, менежментийн
хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

С.Сэржжаргал

Өмчийн төлөөлөл, менежментийн
хэлтсийн ахлах мэргэжилтэн

Комиссын нарийн бичиг:

Б.Эрдэнэмөнх

Өмчийн мэдээлэл, хяналт ашиглалтын
хэлтсийн мэргэжилтэн